



БАТЛАВ.  
БИГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
... Г.МӨНХБАЯР  
2024 оны 04 дугаар сарын 17-ний өдөр

**“ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ”  
АЖЛЫН ДААЛГАВАР**


2024.04.17

Жаргалант

1	Ажлын нэр	3 ширхэг гүн өрмийн инженерийн хийцтэй худаг шинээр гаргах
2	Зориулалт, хүчин чадал	Говь-Алтай аймгийн Бигэр сумд бэлчээр усжуулах, хүн амын унд ахуйд хэрэглэх зориулалтаар 3 ширхэг гүн өрмийн худгийг шинээр гарган усаар хангах. 1. Мянгай баг Ховдлын тал 2. Уртын гол баг Халзан сайр 3. Хүрэмт баг Бага хөв
3	Төслийн захиалагч болон өмчлөгч	Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар
4	Гүйцэтгэгч	Гүн өрмийн худаг гаргаж байсан туршлагатай, техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинтэй байх
5	Ажил гүйцэтгэх хугацаа	2024.04.17-аас 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэл
6	Ажилд тавигдах шаардлага	1. Цооног ухах цооногийг тоноглох 1.1. Цооногийн ашиглалтын ундарга : 1,5м <sup>3</sup> -3м <sup>3</sup> ус өгөх хүчин чадалтай байна. 1.2. Усан сангийн диаметр 1 м-ээс багагүй, материал нь бетон болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн байна. 1.3. Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна 1.4. Тунгаагуурын гүн 1 м –ээс багагүй 1.5. Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 6 цагаас багагүй 1.6. Усны чанарын сорил авч шинжилгээ хийлгэсэн байна. 1.7. Худгийн цооногийг мэрэгч орохооргүй тагаар тоноглох 1.8. Худгийн өрөмдлөгийн гүн : 60 м-ээс багагүй цооногтой байна 2. Худгийн мал услах онгоц, талбай барих • Мал услах онгоцны хэмжээ: 7 м-ээс багагүй урттай 400 мм-ийн голчтой хагас цилиндр, Материал: цутгамал бетон байх • Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2 м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нүх гаргана. 2.2 Мал услах талбай: • Хэмжээ: ний уртын дагуу 2 талдаа 2 м өргөнтэй, зузаан нь 10 см

		<ul style="list-style-type: none"> <li>• Материал: 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө.</li> <li>• Услах талбай нь мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.</li> </ul> <p>3. Худгийн насос, бага оврын цахиалгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар</p> <p>3.1. Насос: 0,2 л/сек-ээс багагүй ус өргөх хүчин чадалтай байх</p> <p>3.2. Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан насосоос хянах самбарт хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх хананд 2 м тутамд хавчиж тогооно.</p> <p>3.3. Хянах самбар: асааж унтаах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай.</p> <p>3.4. Бага оврын цахилгаан үүсгүүр: бензинээр ажилладаг Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх, техникийн үзүүлэлт, ашиглалтын заавартай байх</p> <p>4. Худгийн барилга 3х3х2,2 метр хэмжээтэй төмөр эсвэл блокон ханатай, банзан дээвэртэй дээврийн гадна хэсгийг төмөрлөсөн хийцтэй байх.</p>
7	Цаашид:	<ul style="list-style-type: none"> <li>• Эзэмшигч худгийн барилгыг цоожлон ашиглалтын хугацаанд ашиглагч өрх бүрт түлхүүрийг хувиан өгч худгийг нийт дундаа ашиглана.</li> <li>• Худгийн усны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хариуцан Засвар үйлчилгээг ашиглагч өрхүүд дундын хөрөнгөөр гүйцэтгэнэ.</li> </ul>
8	Уст цэгийн хайгуул хийсэн, эсэх	<ul style="list-style-type: none"> <li>• Хийгээгүй</li> </ul>
9	Нийт төсөв:	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан 105,000,000 /нэг зуун таван сая/ төгрөг

ХЯНАСАН:  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  Н.БУЛГАН

БОЛОВСРУУЛСАН:  
ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН  
МЭРГЭЖИЛТЭН  Б.МЯНГАНБАЯР

